



# СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ᠮᠤᠩᠭᠡᠯᠡᠭᠦᠨ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠳᠡᠷᠭᠡᠳᠡᠬᠡ ᠰᠠᠲᠢᠰᠲᠢᠻᠢᠬᠢᠶᠢᠨ ᠬᠡᠯᠲᠡᠰ

## СЭЛЭНГЭ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

### 2020 I-VIII



Мэдээллийн нэгдсэн лавлах: [WWW.1212.MN](http://WWW.1212.MN)



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН НИЙГЭМ,  
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**

08 сар  
2020

Сүхбаатар сум



## ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл .....	3
АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР .....	4
1. ХҮН АМ, НИЙГМИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ .....	14
1.1 ХҮН АМ .....	14
1.2 ЭРҮҮЛ МЭНД .....	15
1.3 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ .....	21
1.4 НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ .....	23
1.5 ГЭМТ ХЭРЭГ .....	24
2. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ .....	26
2.1 МӨНГӨ, ЗЭЭЛ .....	26
2.2 АЙМГИЙН НЭГДСЭН ТӨСӨВ, ТАТВАР .....	28
2.3 ГАДААД ХУДАЛДАА .....	30
2.4 ҮНЭ .....	30
3. ЭДИЙН ЗАСГИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ .....	38
3.1 АЖ ҮЙЛДВЭР .....	38
4. БУСАД .....	40



## Ерөнхий тэмдэглэл

### I. Товчилсон тэмдэглэлгээ:

ГХ- Гэмт хэрэг

Х.н-Хэмжих нэгж

ХАА- Хөдөө аж ахуй

АҮ - Аж үйлдвэр

ЖДҮ- Жижиг дунд үйлдвэрлэл

СЭ - Сэлэнгэ

НХ – Нийгмийн халамж

ХЧТА-Хөдөлмөрийн чадвараа түр алдсан

ЖА-Жирэмсний амралт

ҮОМШӨ-Үйлдэрийн осол мэргэжлээс шалгаалах өвчин

НӨАТ-Нэмэгдсэн өртгийн албан татвар

ВХЭХӨЭ- Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх

ГӨЭ-Газар өмчлөх эрх

ШША-Шүүхийн шинжилгээний алба

ШШГГ-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар

НДШ-Нийгмийн даатгалын шимтгэл

ОЖД-Олон жилийн дундаж

### II. Саруудыг ромбо тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V, VI ...г.м)

### III. Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-XI зэргээр илэрхийлэв.

### IV. Дараах тэмдэглэлийг ашиглав:

... Мэдээлэл байхгүй

X Бүтцийн өөрчлөлт

0.0 Маш бага тоо

+, - Зөрүү

- Гүйцэтгэл байхгүй

\* Дахин

"Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

### V. "Төл" нь төлөвлөгөө, "Гүйц" нь гүйцэтгэл

### VI. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100.0 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.



## АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

**Төсөв:** Аймгийн төсвийн орлого зарлага нь төвлөрсөн төсвийн болон орон нутгийн төсвийн орлого, зарлагаас бүрдэнэ.

**Ажилгүйчүүд:** Ажилгүйчүүдийн тоонд олон улсын стандарт ангиллын дагуу Монгол улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй эрж, хайж байгаа хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн хүмүүс орно.

**Бүртгэлтэй ажилгүй иргэд:** Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн төв бирж, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

**Нийгмийн даатгал:** нь иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм. Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ. Нийгмийн даатгалын хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчид тооцно.

**Үнэ:** Аймгийн төвийн захад борлогдож байгаа болон хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийг харуулна.

**Хэрэглээний үнийн индекс:** Өрх орлогоороо өөрсдийн хэрэгцээнд худалдан авсан, үйлчлүүлсэн хамгийн чухал эн тэргүүний нийтлэг хэрэгцээтэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тэдгээрийн хэрэглээний зардалд эзлэх хувиар жигнэсэн дундаж юм.



**Гэмт хэрэг:** Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүй алах хэргийг, хүүхэд гэр бүл нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулав.

**Хээлтэгч мал:** Нас гүйцсэн эм малыг хамруулна.

**Зүй бусаар хорогдсон малын тоонд:** Халдвартай , халдваргүй өвчин, зуд, үер ус, гал түймэр, аянга, цахилгаан зэрэг гэнэтийн аюул болон араатан, жигүүртэнд идүүлэх, худаг, хавцалд унах зэрэг хариулга, маллагаатай холбоотой бусад шалтгаанаар хорогдсон малыг хамруулна.

**Аж үйлдвэр:** Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна. Үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил үйлчилгээний хэмжээ юм. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний өсөлтийг тооцоход нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2016 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

**Сэлэнгэ аймгийн нийгэм, эдийн засгийн байдал**

(2020 оны эхний 8 сарын байдлаар)

**1. НИЙГМИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ****1.1 Хүн ам**


2020 оны эхний 8 сарын байдлаар манай аймагт бусад аймаг хотоос бүгд 1 074 хүн шилжин ирсэн нь өмнөх оны мөн үеэс 800 (42.7%) хүнээр буурсан үзүүлэлттэй байна. Нийт шилжин ирэгсдийн 622 (57.9%) нь эрэгтэйчүүд, 452 (42.1%) нь эмэгтэйчүүд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэйчүүдийн тоо 304 (32.5%) хүнээр, эмэгтэйчүүдийн тоо 487 (51.9%) хүнээр тус тус буурсан байна.

**1.2 Эрүүл мэнд**

2020 оны 8 дугаар сарын байдлаар аймгийн хэмжээгээр нийт 1 117 эх амаржиж, 1 129 хүүхэд төрүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеэс амаржсан эх 60 (5.1%)-аар, амьд төрсөн хүүхэд 52 (4.4%)-оор буурсан байна. Төрөлтийг насны бүтцээр нь харахад 25-29 насны 310 (27.7%), 30-34 насны 296 (26.5%), 20-24 насны 241 (21.6%), 35-39 насны 170 (15.2%), 40-44 насны 42 (3.8%), 45-49 насны 1(0.1%), 20 хүртэлх насны 57 (5.1%)-ийг тус тус эзэлж байна.

Нас барсан хүний тоо 329 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 5 (1.5%)-аар буурсан байна. Нийт нас баралтын шалтгааны 39.2 хувь нь зүрх судасны тогтолцооны өвчин, 32.5 хувь нь хорт хавдар, 10.0 хувь нь осол гэмтэл, 5.2 хувь нь хоол боловсруулах, 4.3 хувь нь амьсгалын тогтолцооны, 8.8 хувь нь бусад өвчин эзэлж байна.

0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 7, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 5 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 1-5 насны хүүхдийн эндэгдэл 2 (20.0%)-оор өссөн үзүүлэлттэй байна.

**Төрсөн эх, амьд төрсөн хүүхэд**



Халдварт өвчнөөр 546 хүн өвчилж бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 79 (16.9%)-өөр нэмэгдсэн байна. Нийт халдварт өвчний 76.6 хувийг бэлгийн замын халдварт өвчин, 15.7 хувийг сүрьеэ, 7.7 хувийг бусад халдварт өвчин эзэлж байна.

2020 оны 8 дугаар сард нийт 250 423 үзлэг хийсний 23.9 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 22.7 хувь нь гэрийн идэвхтэй үзлэг, 32.9 хувь нь диспансерийн хяналтын үзлэг эзэлж, нийт 20 826 дуудлагад үйлчилсний 13.2 хувийг алсын дуудлагаар үйлчилж яаралтай тусламж үзүүлсэн.




### 1.3 Хөдөлмөр

2020 оны 8 дугаар сарын байдлаар бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 595 болсон нь өмнөх оны мөн үеэс 42 (6.6%) хүнээр, өмнөх сараас 141 (23.6%) хүнээр тус тус буурсан байна. Нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 595 болсны 281 (47.2%) нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 53.9 хувийг ерөнхий боловсролтой, 27.7 хувийг дээд боловсролтой, 11.8 хувийг мэргэжилтэй ажилчид, 6.4 хувийг тусгай дунд боловсролтой, 0.2 хувийг боловсролгүй хүмүүс эзлэх боллоо. Шинэ ажлын байранд 478 иргэн ажилд зуучлагдсаны 178 иргэн ХАА, Ойн аж ахуй, загас ан ангнуурын салбарт, 84 иргэн боловсролын салбарт, 70 иргэн боловсруулах үйлдвэрт, 41 иргэн уул уурхай, олборлох үйлдвэрт, 10 иргэн тээвэр, холбооны салбарт, 95 иргэн бусад салбарт ажилд орсон байна.

Энэ сард бүртгэлтэй ажилгүйчүүдээс 83 хүн ажилд зуучлагдан орж, 218 хүн идэвхгүйн улмаас хасагдаж, 160 хүн шинээр бүртгэгдсэн байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролоор




### 1.4 Нийгмийн даатгал, халамж

2020 оны 8 дугаар сарын байдлаар тэтгэврийн даатгалын сангаас 17 596 тэтгэвэр авагчдад 54 259.6 сая төгрөгийг олгосон нь өмнөх оны мөн үеэс тэтгэвэр авагчид 817 (4.9%) хүнээр, олгосон тэтгэврийн хэмжээ 7 485.2 (15.9%) сая төгрөгөөр тус тус өссөн байна. Тэтгэмжийн даатгалын сангаас 3 973 хүнд 2 182.5 сая төгрөгийг хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсэн амаржсан, оршуулгын тэтгэмжид, үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин, даатгалын сангаас үйлдвэрлэлийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 247 хүнд 774.2 мянган төгрөг, Ажилгүйдлийн даатгалын сангаас 277 хүнд 735.5 мянган төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид тус тус олгожээ.



Нийгмийн халамжийн сангаас 36 954 хүнд 11 499.9 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг олгосон нь өмнөх оны мөн үеэс нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авагчид 2 464 (6.3%) хүнээр буурч, олгосон тэтгэвэр тэтгэмжийн хэмжээ 1 501.9 (15.5%) сая төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн даатгалын орлого, сая. төг




### 1.5 Гэмт хэрэг

2020 оны эхний 8 сарын байдлаар Цагдаагийн газрын мэдээгээр нийт 400 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 128 (24.2%) –аар буурсан байна. Нийт гэмт хэргийн 97 (24.3%) нь согтуугаар үйлдэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 20 (17.1%)–оор буурсан байна.

Иргэн болон байгууллагад нийт 955.8 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үеэс 686.7 (41.8%) сая төгрөгөөр буурсан байна. Учирсан хохирлоос 448.4 сая төгрөгийг нөхөн төлүүлж, нөхөн төлөлт 46.9 хувьтай байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 165 (41.2%) нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 143 (35.7%) нь хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 37 (9.3%) нь байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, 19 (4.8%) нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 36 (9.0%) нь бусад төрлийн гэмт хэрэг эзэлж байна. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 42 (25.4%) нь малын хулгай байгаа нь өмнөх оны мөн үеэс 4 (10.5%)–өөр нэмэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэрэг, төрлөөр, хувиар






### 1.6 Хилээр орсон, гарсан иргэд

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг болон Сүхбаатар боомтоор давхардсан тоогоор 110.4 мянган зорчигч нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеэс 338.3 (75.4%) мянган хүнээр буурсан байна. Нийт зорчигчдын 79.0 (71.5%) мянга нь Монгол иргэд, 31.4 (28.5%) мянга нь гадаад иргэд байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хилээр нэвтэрсэн Монгол иргэдийн тоо 271.4 (77.5%) мянган хүнээр, гадаад иргэдийн тоо 66.8 (68.0%) мянган хүнээр тус тус буурсан үзүүлэлтэй байна.

Монгол-Оросын хилийг хялбарчилсан журмаар хил нэвтрэх эрхийн үнэмлэхээр 5 202 хүн зорчсон байна.

#### Хилээр орсон гарсан иргэд




## 2. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ



### 2.1 Мөнгө, банк

Монгол банкны мэдээгээр зээлийн өрийн үлдэгдэл 274 694.6 сая төгрөг байгаа ба үүний 3.3 хувийг чанаргүй зээл эзэлж байна. Нийт харилцахын үлдэгдэл 43 894.1 сая төгрөг, мөнгөн хадгаламж 130 610.9 сая төгрөг байна. Аймгийн хэмжээнд банкны нийт 64 салбар нэгжид 378 ажилтан ажиллаж байна.

#### Зээлийн өрийн үлдэгдэл /тэрбум.төг/





## 2.2 Төрийн сан, татвар

2020 оны 8 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр орон нутгийн төсвийн орлого 14 452.2 сая (96.6%) төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна. Үүнээс аймгийн төсвийн орлого 10 549.2 сая (92.0%) төгрөгийн гүйцэтгэлтэй, сумдын төсвийн орлого 3 903.0 сая (111.5%) төгрөгийн гүйцэтгэлтэй байна. 2020 оны 8 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр орон нутгийн төсвийн зарлага 52 002.6 сая (76.8%) төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна. Үүнээс орон нутгийн төсвийн байгууллагуудын зарлага 18 773.9 сая (73.9%), Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зарлага 33 228.7 сая (78.6%) төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Сумдад 8 881.8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, 34 230.7 сая төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлэг, 1 810.0 сая төгрөгийн орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг тус тус шилжүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн гүйцэтгэл 298.4 сая (98.7%) төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна.


Орон нутгийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /сая.төг/



## 2.3 Гадаад худалдаа

Сэлэнгэ аймагт 2020 оны эхний 8 сарын байдлаар гадаад худалдааны нийт бараа эргэлт 141.3 сая америк доллар, үүнээс экспорт 1.5 сая америк доллар, импорт 139.8 сая америк доллар байна. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 61.5 (30.4%) сая америк доллараар, экспорт 1.9 (56.8%) сая америк доллараар, импорт 59.6 (29.9%) сая америк доллараар тус тус буурсан байна.

Гадаад худалдааны бараа эргэлт, сая.\$






## 2.4 Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 8 сард өмнөх сараас 1.0 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 1.9 хувиар өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 1.9 хувиар өсөхөд согтууруулах ундаа тамхи мансууруулах бодис 5.3 хувь, хүнсний бараа согтууруулах бус ундаа 4.1 хувь, гэр ахуйн тавилга гэр ахуйн бараа 3.0 хувь, хувцас, бөс бараа, гутал 2.7 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш 1.3 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ 0.2 хувиар тус тус өсөж, тээврийн бүлэг 5.1 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 1.0 хувиар буурахад тээврийн бүлэг 1.4 хувь, хувцас, бөс бараа, гутал 0.4 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ 0.1 хувиар өсөж, хүнсний бараа согтууруулах бус ундаа 3.7 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.



## ХАА-н бүтээгдэхүүний үнэ.

Малын үнэ 2019 оны мөн үеэс бод малын хувьд үнийн өөрчлөлтгүй, бог малын хувьд 10.000-50.000 төгрөгөөр өссөн байна. Түүхий эдийн үнийн хувьд адууны дэл сүүл 2 000 төгрөгөөр худалдаалагдаж байна.



## 2.5 Хөдөө аж ахуй

2020 оны тариалалтын мэдээгээр Сэлэнгэ аймаг 166.2 мян.га-д үр тариа, 2.9 мян.га-д төмс, 3.0 мян.га-д хүнсний ногоо, 27.5 мян.га-д техникийн ургамал тариалсан байна. Үүнийг 2019 оны мөн үетэй харьцуулахад үр тариа 12.8 (8.4%) мян.га, төмс 0.4 (16.9%) мян.га, хүнсний ногоо 0.5 (22.0%) мян.га-р тус бүр их, харин техникийн ургамал 8.2 мян.га (23.0%) бага тариалсан байна.

2020 оны 8 дугаар сарын ургац хураалтын явцын мэдээгээр төмс 3.1 мян.тн, хүнсний ногоо 5.4 мян.тн хураан авчээ. Үүнийг 2019 оны мөн үетэй харьцуулахад төмс 0.2 (8.1%) мян.тонн, хүнсний ногоо 0.5 (6.9%) мян.тонн-р тус тус их ургац хураан авсан байна.




### 3.ЭДИЙН ЗАСГИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ



#### 3.1 Аж үйлдвэр

2020 оны эхний 8 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарт 368.9 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 428.9 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн нь урьд оны мөн үеэс үйлдвэрлэлт 62.5 (20.4%) тэрбум төгрөгөөр, борлуулалт 100.8 (30.7%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 239.6 (64.9%) тэрбум төгрөг нь уул уурхайн салбарт, 121.8 (33.0%) тэрбум төгрөг нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 7.5 (2.1%) тэрбум төгрөг нь цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж, хог хаягдал цэвэрлэх салбарт бүтээгджээ.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалт (тэрбум төг)



### 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ



#### 4.1 Цаг уур орчны мэдээ

##### ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

###### Уур амьсгалын тойм

Есдүгээр сард агаарын температурын ОЖД нь Сэлэнгэ аймгийн нутгаар 9-12 градус дулаан байдаг байна. Гэвч 1970, 1985, 2011 онд ихэнх сумдын нутгаар 1.5– 3.5<sup>o</sup>C-аар хүйтэн байсан бол 1966, 1973, 1977, 1978, 1988, 2019 онд ихэнх сумдын нутгаар олон жилийн дунджаас 1.5– 2.5<sup>o</sup>C-аар, 1998, 2000-2002, 2007, 2019 онд 2.5– 5.7<sup>o</sup>C-р дулаан байжээ. Агаарын үнэмлэхүй их температур 24– 29<sup>o</sup>C хүрч дулаардаг бол үнэмлэхүй бага температур 8-14<sup>o</sup>C хүрч хүйтэрдэг байна. Зарим жилд Сэлэнгэ аймгийн нутгаар шөнөдөө 3-8 градус хүрч цочир хүйтэрдэг бөгөөд энэ нь арван жил тутамд 1-3 удаа тохиолддог.



Хур тунадасны хувьд: ОЖД-аар Сэлэнгэ аймгийн нутгаар 21-36 мм ордог. Гэвч зарим жил үүнээс нилээд хэлбэлзэлтэй байдаг. Тухайлбал: 1973, 1975, 1984, 1987, 1991, 1994, 1999 онд ихэнх сумдын нутгаар олон жилийн дунджаас их хур тунадас орсон бол 1965-1967, 1978, 1980, 1995, 1996, 2000, 2002, 2006, 2019 онд харьцангуй бага хур тунадас орж байжээ.

## **ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ**

**Агаарын температурын хувьд:** Энэ сард агаарын дундаж температур Сэлэнгэ аймгийн нутгаар ОЖД-ийн орчим буюу 9-12 градус дулаан байна.

Нэг ба хоёрдугаар арав хоногийн эхээр, гуравдугаар арав хоногийн дунд үеэр агаарын температур өмнөх үеэсээ 3 – 5<sup>0</sup>С – аар хүйтэрч, агаар болон хөрсөн дээр цочир хүйтэрч болзошгүй байна.

**Хур тунадасны хувьд:** Сэлэнгэ аймгийн нийт нутгаар ОЖД – ийн орчим буюу 21-38 мм орох төлөвтэй байна.

Нэгдүгээр арав хоногийн эхээр ихэнх сумдын нутгаар бороо, хоёр, гуравдугаар арав хоногийн эхээр ихэнх сумдын нутгаар хур тунадас, уулархаг нутгаар нойтон цас орох төлөвтэй байна.

Салхи ихэнх хугацаанд 5 – 10 м/с, нэг, хоёр, гуравдугаар арав хоногийн эхээр зарим үед 14 – 16 м/с хүртэл ширүүснэ.

## **5. БУСАД**

### **А. Хяналт шалгалт**

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар 2020 оны эхний 8 сарын байдлаар 196 аж ахуйн нэгж байгууллага, 92 иргэнд шалгалт хийж, 2 558 зөрчил дутагдал илрүүлж, 1 109 зөрчил арилгуулсан байна.

### **Б. Онцгой байдлын газрын мэдээ**

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 179 объект, 131 айл өрхөд үзлэг шалгалт хийж 566 зөрчил илрүүлэн 143 зөрчил дутагдлыг арилгуулсан байна. 2020 оны эхний 8 сарын байдлаар объектод 75, ой хээрийн 9 гал түймэр гарч 290.2 сая төгрөгийн хохирол учирсан байна.

### **В. Түүвэр судалгаа**

2020 оны 8 сарын байдлаар Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааг 416 өрхөөс, Ажиллах хүчний судалгааг 420 өрхөөс авч, судалгаанд хамрагдсан өрхүүдэд урамшуулал болгон 4 712.0 мянган төгрөг олгоод байна.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА            Д.ГҮНДЭГМАА



# 1. ХҮН АМ, НИЙГМИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ


## 1.1 Хүн ам

### 1.1.1 ШИЛЖИЖ ИРСЭН ИРГЭДИЙН ТОО, сумаар

Сумын нэр	2016 I-VIII	2017 I-VIII	2018 I-VIII		2019 I-VIII		2020 I-VIII	
			Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
<b>Дүн</b>	<b>854</b>	<b>1 211</b>	<b>1 760</b>	<b>926</b>	<b>1 874</b>	<b>939</b>	<b>1 074</b>	<b>452</b>
Алтанбулаг	40	52	27	12	25	14	5	4
Ерөө	36	55	87	45	102	46	41	24
Зүүнбүрэн	19	30	50	30	47	21	37	15
Мандал	175	218	639	360	613	297	378	152
Орхон	13	21	33	15	30	12	50	14
Сант	14	25	45	22	55	25	50	16
Цагааннуур	26	43	40	20	66	36	19	10
Баянгол	66	63	90	42	137	74	52	16
Сайхан	83	167	207	101	284	141	73	36
Орхонтуул	39	39	43	26	46	25	33	16
Баруунбүрэн	40	25	41	22	69	38	55	16
Шаамар	39	33	72	38	70	38	43	19
Хүдэр	32	31	23	9	48	21	11	5
Сүхбаатар	179	309	298	154	176	100	86	45
Жавхлант	25	39	12	5	32	15	69	28
Түшиг	16	33	26	13	35	19	54	30
Хушаат	12	28	27	12	39	17	18	6

Эх үүсвэр: Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс

### Шилжиж ирсэн иргэдийн тоо



**1.2 ЭРҮҮЛ МЭНД****1.2.1 ТӨРӨЛТ**

Сумын нэр	Төрсөн эх				<u>2020 I-VIII</u> <u>2019 I-VIII</u>
	2017 I-VIII	2018 I-VIII	2019 I-VIII	2020 I-VIII	
<b>ДҮН</b>	<b>1 128</b>	<b>1 142</b>	<b>1 177</b>	<b>1 117</b>	<b>94.9</b>
Алтанбулаг	2	1			
Ерөө	23	37	24	27	112.5
Зүүнбүрэн	2	4	3	1	33.3
Мандал	405	402	400	445	111.3
Орхон			1	1	100.0
Сант				1	
Цагааннуур	11	13	6	4	66.7
Баянгол	4	2	2		
Сайхан	57	67	59	57	96.6
Орхонтуул	4	7	3		
Баруунбүрэн	2	6	1	2	2.0*
Шаамар	1	2		3	
Хүдэр	2	2	2	3	150.0
Сүхбаатар	602	588	662	572	86.4
Жавхлант	1	1	2		
Түшиг	12	9	12	1	8.3
Хушаат		1			

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

**1.2.2 АМЬД ТӨРСӨН ХҮҮХДИЙН ТОО**

Сумын нэр	Амьд төрсөн хүүхэд								<u>2020 I-VIII</u> <u>2019 I-VIII</u>
	2017 I-VIII		2018 I-VIII		2019 I-VIII		2020 I-VIII		
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	
<b>Бүгд</b>	<b>1 133</b>	<b>548</b>	<b>1 142</b>	<b>532</b>	<b>1 181</b>	<b>551</b>	<b>1 129</b>	<b>566</b>	<b>95.6</b>
Алтанбулаг	2	1	1						
Ерөө	24	14	38	20	25	10	27	14	108.0
Зүүнбүрэн	2	1	3	2	3	1	1	1	33.3
Мандал	408	195	402	191	403	190	451	238	111.9
Орхон					1		1		100.0
Сант							1		
Цагааннуур	10	5	13	6	6	3	3	1	50.0
Баянгол	4	2	2		2	1			
Сайхан	57	29	67	31	59	27	57	25	96.6
Орхонтуул	4	2	7	2	3	2			
Баруунбүрэн	2	2	5	4	1		1		100.0
Шаамар	1		2	1			3	1	
Хүдэр	2	2	2		2		3	1	150.0
Сүхбаатар	604	289	588	267	662	310	580	285	87.6
Жавхлант	1	1	1	1	2				
Түшиг	12	5	10	7	12	7	1		8.3
Хушаат			1						

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар



2020 оны 08 сар

**1.2.3 ТӨРСӨН ЭХ, боловсролоор**

Үзүүлэлт	2017 I-VIII	2018 I-VIII	2019 I-VIII	2020 I-VIII	$\frac{2020 \text{ I-V III}}{2019 \text{ I-VIII}}$
<b>Бүгд</b>	<b>1 128</b>	<b>1 142</b>	<b>1 177</b>	<b>1 117</b>	<b>94.9</b>
Дээд боловсрол	259	265	295	301	102.0
Мэргэжлийн болон техникийн боловсрол	55	48	51	61	119.6
Дунд боловсрол	730	765	750	686	91.5
Бага боловсрол	69	48	54	57	105.6
Боловсролгүй	15	16	27	12	44.4

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

**Төрсөн эх, боловсролоор****1.2.4 ТӨРСӨН ЭХ, насны бүлгээр**

Үзүүлэлт	2017 I-VIII	2018 I-VIII	2019 I-VIII	2020 I-VIII	$\frac{2020 \text{ I-V III}}{2019 \text{ I-VIII}}$
<b>Бүгд</b>	<b>1 128</b>	<b>1 142</b>	<b>1 177</b>	<b>1 117</b>	<b>94.9</b>
20 хүртэлх	78	61	61	57	93.4
20 - 24	300	278	267	241	90.3
25 - 29	335	363	338	310	91.7
30 - 34	240	247	312	296	94.9
35 - 39	146	166	172	170	98.8
40 - 44	29	26	26	42	161.5
45 - 49		1	1	1	100.0

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар



**1.2.5 НАС БАРАЛТ**

Сумын нэр	Нас баралт								<u>2020 I-VIII</u> <u>2019 I-VIII</u>
	2017 I-VIII		2018 I-VIII		2019 I-VIII		2020 I-VIII		
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	
<b>Бүгд</b>	<b>317</b>	<b>123</b>	<b>328</b>	<b>122</b>	<b>334</b>	<b>125</b>	<b>329</b>	<b>126</b>	<b>98.5</b>
Алтанбулаг	15	5	22	6	15	3	14	6	93.3
Ерөө	30	9	21	6	22	4	23	10	104.5
Зүүнбүрэн	7	3	8	3	8	2	11	4	137.5
Мандал	81	25	95	39	72	32	90	37	125.0
Орхон	8	3	9	1	5	1	6	2	120.0
Сант	4	2	4	2	12	6	6	1	50.0
Цагааннуур	14	4	12	7	14	6	14	6	100.0
Баянгол	14	6	4	2	11	2	14	5	127.3
Сайхан	24	10	30	11	30	13	14	5	46.7
Орхонтуул	9	6	7	2	15	4	16	5	106.7
Баруунбүрэн	9	5	7	4	15	9	3	3	20.0
Шаамар	16	8	14	6	16	6	17	2	106.3
Хүдэр	7	1	6	3	5	1	7	2	140.0
Сүхбаатар	70	35	72	24	82	30	81	35	98.8
Жавхлант	4		6	3	2	1	7	2	3.5*
Түшиг	2		8	2	3	3	2		66.7
Хушаат	3	1	3	1	7	2	4	1	57.1

**1.2.6 НАС БАРАЛТ, насны бүлгээр**

Үзүүлэлт	2017 I-VIII	2018 I-VIII	2019 I-VIII	2020 I-VIII	<u>2020 I-V III</u> <u>2019 I-VIII</u>
<b>Бүгд</b>	<b>317</b>	<b>328</b>	<b>334</b>	<b>329</b>	<b>98.5</b>
Эмэгтэй	123	122	125	129	103.2
0 - 1	12	12	6	7	116.7
1 - 5	4	3	4	5	125.0
6 - 18	7	4	4	6	150.0
19 - 54	107	100	91	68	74.7
54-с дээш	187	209	229	243	106.1

**1.2.7 НАС БАРАЛТ, зонхилох өвчний ангиллаар**

Үзүүлэлт	Нас барсан хүний тоо				<u>2020 I-VIII</u> <u>2019 I-VIII</u>
	2017 I-VIII	2018 I-VIII	2019 I-VIII	2020 I-VIII	
<b>Дүн</b>	<b>317</b>	<b>328</b>	<b>334</b>	<b>329</b>	<b>98.5</b>
Зүрх судасны тогтолцооны өвчин	122	131	149	129	86.6
Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	46	41	38	33	86.8
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	31	25	21	17	81.0
Амьсгалын тогтолцооны өвчин	1	15	13	14	107.7
Хавдар	83	91	85	107	125.9
Бусад	34	25	28	29	103.6

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

**1.2.8 НЯЛХСЫН ЭНДЭГДЭЛ**

умын нэр	0-1 хүртэлх насны хүүхэд			
	2017 I-VIII	2018 I-VIII	2019 I-VIII	2020 I-VIII
<b>Дүн</b>	<b>12</b>	<b>12</b>	<b>6</b>	<b>7</b>
Алтанбулаг	1			
Ерөө	2			
Зүүнбүрэн		1		
Мандал	3	2		2
Орхон				
Сант				
Цагааннуур	2		1	
Баянгол	1			
Сайхан		1	1	
Орхонтуул				
Баруунбүрэн				
Шаамар				
Хүдэр				
Сүхбаатар	3	8	4	5
Жавхлант				
Түшиг				
Хушаат				

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

## 1.2.8-н үргэлжлэл

Сумын нэр	1-5 насны хүүхэд			
	2017 I-VIII	2018 I-VIII	2019 I-VIII	2020 I-VIII
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>
Алтанбулаг				
Ерөө	1			1
Зүүнбүрэн				
Мандал	1	1	1	1
Орхон				
Сант				
Цагааннуур				2
Баянгол				
Сайхан	1		1	
Орхонтуул				
Баруунбүрэн				
Шаамар				
Хүдэр				
Сүхбаатар		1	2	1
Жавхлант		1		
Түшиг				
Хушаат				

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

**1.2.9 ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГСӨД**

Сумын нэр	Бүх халдварт өвчин				2020 I-VIII 2019 I-VIII
	2017 I-VIII	2018 I-VIII	2019 I-VIII	2020 I-VIII	
<b>ДҮН</b>	<b>468</b>	<b>597</b>	<b>467</b>	<b>546</b>	<b>116.9</b>
Алтанбулаг	29	50	29	54	186.2
Ерөө	19	27	15	26	173.3
Зүүнбүрэн	22	8	7	6	85.7
Мандал	62	89	96	115	119.8
Орхон	3	10	4	1	25.0
Сант	1	1	1	13	13.0*
Цагааннуур	24	27	17	17	100.0
Баянгол	6	36	12	8	66.7
Сайхан	24	36	31	32	103.2
Орхонтуул	8	6	7	13	185.7
Баруунбүрэн	1	3	2	2	100.0
Шаамар	33	16	17	28	164.7
Хүдэр	14	10	2	23	11.5*
Сүхбаатар	208	247	198	183	92.4
Жавхлант	3	6	4	20	5.0*
Түшиг	7	22	8	4	50.0
Хушаат	4	3	17	1	5.9

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

Сумын нэр	Бэлгийн замын өвчин				2020 I-VIII 2019 I-VIII
	2017 I-VIII	2018 I-VIII	2019 I-VIII	2020 I-VIII	
<b>ДҮН</b>	<b>235</b>	<b>405</b>	<b>274</b>	<b>418</b>	<b>152.6</b>
Алтанбулаг	13	39	12	48	4.1*
Ерөө	4	10	5	18	3.8*
Зүүнбүрэн	10	7	5	6	120.0
Мандал	26	56	48	74	154.2
Орхон		9	3		
Сант	1	1	1	12	12.0*
Цагааннуур	16	21	11	14	127.3
Баянгол		22	3	3	100.0
Сайхан	8	32	15	27	3.0*
Орхонтуул	3	2	2	5	4.5*
Баруунбүрэн			1	2	2.0*
Шаамар	19	10	13	24	184.6
Хүдэр	6	2		20	
Сүхбаатар	122	175	143	143	100.0
Жавхлант	2	2	4	19	4.7*
Түшиг	5	17	7	2	28.6
Хушаат			1	1	100.0

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар



Сумын нэр	Гипатит				<u>2020 I-VIII</u> <u>2019 I-VIII</u>
	2017 I-VIII	2018 I-VIII	2019 I-VIII	2020 I-VIII	
<b>ДҮН</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>2</b>	<b>66.7</b>
Алтанбулаг		1	1		
Ерөө				1	
Зүүнбүрэн					
Мандал					
Орхон					
Сант					
Цагааннуур					
Баянгол					
Сайхан					
Орхонтуул				1	
Баруунбүрэн					
Шаамар			1		
Хүдэр					
Сүхбаатар			1		
Жавхлант					
Түшиг					
Хушаат		1			

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

Сумын нэр	Сүрьеэ				<u>2020 I-VIII</u> <u>2019 I-VIII</u>
	2017 I-VIII	2018 I-VIII	2019 I-VIII	2020 I-VIII	
<b>ДҮН</b>	<b>141</b>	<b>123</b>	<b>121</b>	<b>86</b>	<b>71.1</b>
Алтанбулаг	12	6	13	4	30.8
Ерөө	10	14	10	6	60.0
Зүүнбүрэн			2		
Мандал	33	29	37	33	89.2
Орхон	3	1	1	1	100.0
Сант				1	
Цагааннуур	8	5	3	2	66.7
Баянгол	6	13	9	5	55.6
Сайхан	10	4	11	5	45.5
Орхонтуул	5	3	5	3	60.0
Баруунбүрэн	1	2	1		
Шаамар		3	2	3	150.0
Хүдэр	3	4	2	2	100.0
Сүхбаатар	46	30	23	19	82.6
Жавхлант		4		1	
Түшиг	2	4	1	1	100.0
Хушаат	2	1	1		

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

**1.3. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ****1.3.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙЧҮҮД**, боловсролоор

үзүүлэлт	2017 I-VIII	2018 I-VIII	2019 I-VIII	2020 I-VIII	<u>2020 I-VIII</u> <u>2019 I-VIII</u>
<b>Бүгд</b>	<b>815</b>	<b>795</b>	<b>637</b>	<b>595</b>	<b>93.4</b>
-Үүнээс эмэгтэй	378	432	340	281	82.6
-Дээд	220	252	163	165	101.2
-Тусгай дунд	49	54	23	38	165.2
-Ерөнхий боловсролтой	437	345	350	321	91.7
-Мэргэжилтэй ажилчид	104	134	95	70	73.7
-Боловсролгүй	5	10	6	1	16.7

Эх үүсвэр: Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

**1.3.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО**, сумаар, эхний 8 сарын байдлаар

Сумын нэр	Сарын эхний ажилгүйчүүд	Тухайн сард хасагдсан		Нэмэгдсэн	Сарын эцэс
		Ажилд зуучлагдсан	Идэвхгүйн улмаас хасагдсан		
<b>ДҮН</b>	<b>736</b>	<b>83</b>	<b>218</b>	<b>160</b>	<b>595</b>
Алтанбулаг	34		18	10	26
Ерөө	57	29	15	13	26
Зүүнбүрэн	48	3	18	13	40
Мандал	200	4	49	36	183
Орхон	8		3	15	20
Сант	14	10	8	11	7
Цагааннуур	63		12	3	54
Баянгол	81	12	23	8	54
Сайхан	30		8	5	27
Орхонтуул	24		1	1	24
Баруунбүрэн	11				11
Шаамар	35		2	2	35
Хүдэр	9	13		10	6
Сүхбаатар	106	2	61	22	65
Жавхлант	5				5
Түшиг	2				2
Хушаат	9	10		11	10

Эх үүсвэр: Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

**1.3.3 ШИНЭ АЖЛЫН БАЙР**

	Бүгд	ХАА, ан агнуур, ОАА, загас агнуур	Уул уурхай, олборлох үйлдвэр	Боловсруулах үйлдвэр	Цахилгаан, дулаан, усан хангамж	Барилга	Худалдаа, гэр ахуйн засвар, үйлчилгээ	Зочид буудал, зоогийн газар	Тээвэр, холбоо	Санхүүгийн үйл ажиллагаа	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа	Боловсрол	Эрүүл мэнд, нийгмийн халамж	Урлаг, үзвэр, үйлчилгээний бусад үйл ажиллагаа
<b>ДҮН</b>	<b>478</b>	<b>178</b>	<b>41</b>	<b>70</b>	<b>6</b>	<b>4</b>	<b>31</b>	<b>5</b>	<b>10</b>	<b>3</b>	<b>3</b>	<b>7</b>	<b>24</b>	<b>84</b>	<b>3</b>	<b>9</b>
Алтанбулаг	14			4										10		
Ерөө	55	14	22	4		2	5		1	2					1	
Зүүнбүрэн	10	2		2			3					3				
Мандал	71	37	1	17		2	5		2	1	3			1		2
Орхон	10	5		1	1									3		
Сант	25	18	1	1					1					3	1	
Цагааннуур	42	6		3			4	2						1	26	
Баянгол	33	8	11	8			1	2				2		1		
Сайхан	42	1												1	40	
Орхонтуул	10	6					1							1		1
Баруунбүрэн	24	22														2
Шаамар	13	1			1				6					5		
Хүдэр	22	6		6	3		7									
Сүхбаатар	46	13	1	18	1		1	1						3	4	4
Жавхлант	22	14		4			1					2		1		
Түшиг	18	7	5	2			2							2		
Хушаат	21	18					1								1	1

Эх үүсвэр: Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

**1.4 НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ****1.4.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ОРЛОГО, АВЛАГА, сумаар, сая.төг**

Сумдын нэр	НДШ-ийн орлого			НДШ-ийн авлага		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Аж ахуйн нэгж	Төсөв	Бүгд
<b>ДҮН</b>	<b>20 890.5</b>	<b>25 421.2</b>	<b>121.7</b>	<b>9 882.9</b>	<b>156.1</b>	<b>10 039.0</b>
Алтанбулаг	312.0	461.4	147.9	38.6	4.8	43.4
Ерөө	2 639.2	1 667.8	63.2	70.7		70.7
Зүүнбүрэн	218.0	275.7	126.5	8.2		8.2
Мандал	5 281.7	6 518.3	123.4	436.0	1.3	437.3
Орхон	138.1	199.3	144.3	7.5	4.3	11.8
Сант	168.2	232.1	138.0	11.6		11.6
Цагааннуур	682.0	675.9	99.1	225.8		225.8
Баянгол	455.3	526.7	115.7	215.1		215.1
Сайхан	2 883.3	3 854.7	133.7	7 083.3	1.5	7 084.8
Орхонтуул	265.2	377.9	142.5	4.3	19.0	23.3
Баруунбүрэн	282.8	330.4	116.8	79.7		79.7
Шаамар	356.9	552.7	154.9	1.6		1.6
Хүдэр	260.7	313.1	120.1	29.1	13.7	42.8
Сүхбаатар	6 365.4	8 663.3	136.1	1 562.6	103.3	1 665.9
Жавхлант	192.6	249.5	129.5	50.4	8.1	58.5
Түшиг	168.3	245.4	145.8	24.6		24.6
Хушаат	220.8	277.0	125.5	33.8	0.1	33.9

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс

**1.4.2 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САН**

Үйлчилгээний төрөл	Хүн	Мөнгөн дүн, сая.төг
1. Халамжийн тэтгэвэр	2 478	4 317.1
2. Нөхцөлт мөнгөн тэтгэмж	1 799	1 096.9
3. Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	1 643	682.3
4. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	390	64.8
5 Жирэмсэн эхчүүдэд олгосон мөнгөн тэтгэмж	1 954	261.5
6.Ахмад дайчин, алдар цолтон ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	72	60.7
7 Эхийн алдар одонтой эхчүүдэд олгосон тусламж	8 656	1 126.6
8.Ахмад настанд үзүүлсэн тусламж,хөнгөлөлт	2 575	284.4
9.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	364	73.9
10.Насны хишиг	5 047	762.6
11.Цалинтай ээж хөтөлбөр	5 950	1 842.8
